



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 206, 207, 210, 213 тоот
7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас: 70592439, 70592208, 70593208

И-мэйл: dundgovi@audit.gov.mn

№ 02/34
танай _____ -ны № _____ -т

**САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА
С.АМАРСАНАА ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Сайхан-Овоо сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитын явцад Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн зээлийн үлдэгдэлд тогтоосон төлбөрийн актыг хүргүүлж байна. Актын төлбөрийг барагдуулж заасан хугацаанд хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт хуудас


ДАРГА **Р.МӨНХТОГТОХ**


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2023 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 21

№/2260314

Мандалговь

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитаар Сайхан-Овоо сумын төсөл хэрэгжүүлэгч Ө.Өлзийбаатар 1,849,450.00 /Нэг сая найман зуун дөчин есөн мянга дөрвөн зуун тавь/, Б.Найдан 3,541,760.00 /Гурван сая таван зуун дөчин нэгэн мянга долоон зуун жар/, Б.Мөнхчимэг 8,903,736.00 /Найман сая есөн зуун гурван мянга долоон зуун гучин зургаа/, Б.Урангоо 3,624,375.00 /Гурван сая зургаан зуун хорин дөрвөн мянга гурван зуун далан тав/ төгрөгийн үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс Хоршоо хөгжүүлэх санд нийт **17,919,321.00 /Арван долоон сая есөн зуун арван есөн мянга гурван зуун хорин нэг/** төгрөгийн хохирол учруулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т /батлагдсан төсөв, хотолборийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Иргэний хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Монгол төлбөрийн үүрэг хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11-д /Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд товчлоулна/, Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох, зээлдэгчтэй байгуулсан гэрээг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т /Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн нийт 17,919,321.00 /Арван долоон сая есөн зуун арван есөн мянга гурван зуун хорин нэг/ төгрөгийн зээл, хүүгийн авлагыг нэр бүхий зээлдэгчээр Сайхан-Овоо сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 100081255406 тоот дансанд 2023 оны 10 дугаар сарын 25-ны дотор нөхөн төлүүлэх.

2. Актын биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг дарга С.Амарсанаа, нягтлан бодогч Э.Наранцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР *Ч.Бэрхсайхан* Ч.БЭРХСАЙХАН

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Р.Мөнхтогтох* Р.МӨНХТОГТОХ



¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593208

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Сайхан-Овоо сумын Хоршоо хөгжүүлэх сан
Тайланг хугацаа: 2022 он

№	Ажил гүйцэтгэний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагч байгууллагын байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл		Шалгагч байгууллагын холбогдох хүний	
							Овог нэр	Овог нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	3	4	5	6	7	8	9	10	
1	Балансан данстай холбоотой	Сайхан-Овоо сумын төсөл хэрэгжүүлэгч Ө.Өлзийбаатар, Б.Найдан, Б.Мөнхчимэг, Б.Ураангоо нар үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлэнээс Хоршоо хөгжүүлэх санд хохирол учруулсан	17,919,321.0	Төлбөрийн акт тогтоох	Аудиторын саналыг хүлээн зөвшөөрч, зөрчлийг арилгана	Заасан хугацаанд зөрчлийг арилгаж, биелэлтийг ирүүлэх	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, Нягтлан бодогч	С.Амарсанаа, Э.Наранцэнэг	
2										
3										
6			17,919,321.00							

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.БЭРХСАЙХАН

Х.НАРАНЦАЦРАЛ

Р.МӨНХТОГТОХ

ЗӨВШӨӨРСӨН: ДАРГА

ЗӨВШӨӨРСӨН: НИЯГТЛАН БОДОГЧ

С.АМАРСАНАА

Э.НАРАНЦЭНЭГ